

## СУРАЛЦАГЧДЫН МЭДЛЭГ, ЧАДВАРЫГ ДҮГНЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 1.1 БСШУ-ны Сайдын 2003 оны 158 дугаар тушаалаар батлагдсан “Дээд боловсролын зэрэг олгох сургалтанд багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадварыг дүгнэхэд баримтлах журам”-ыг үндэслэн “Сэрүүлэг” дээд сургуульд суралцагч оюутны сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих, оюутны мэдлэг, чадварыг дүгнэхэд энэхүү журмыг баримтална
- 1.2 1.2 Оюутны мэдлэг чадвар, гүйцэтгэлийг үнэлэхдээ кредит цагийн үнэлгээний системийг ашиглана. Кредит цагийн үнэлгээ нь оюутан тухайн хичээлийн агуулга эзэмшсэн байдал, мэдлэг чадварын түвшинг илэрхийлэх дүнгийн систем юм.
- 1.3 1.3 Кредит цагийн үнэлгээ нь сургалтын явцад багш оюутны ажлын ачааллыг жигд хуваарилах, оюутанд эзэмшсэн мэдлэг, чадвараа улирлын турш үнэлүүлэх боломж олгоно.
- 1.4 Оюутны эзэмшсэн мэдлэг, чадварыг баталгаажуулах, ажлын дадлага туршлагатай болгох зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулж, гүйцэтгэлийг үнэлж, тооцно.
  - Мэргэжлийн дадлагууд
  - Курсын ажил
  - Хичээлийн явцын үнэлгээ
    - o Ирц, идэвхи
    - o Сэдвийн шалгалт
    - o Бие даалтын ажил
  - Процессын хяналтын шалгалт
  - Улирлын нэгдсэн шалгалт
  - Түвшин тогтоох сорил
  - Олон улсын түвшин тогтоох шалгалт
  - Төслийн ажил
  - Дипломын ажил
  - Төгсөлтийн шалгалт

### Хоёр. Оюутны мэдлэг, чадварыг үнэлж, үнэлгээг тооцох

- 2.1. Суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэхдээ А, В, С, D, F, E, R, U гэсэн үсгэн дүн, 4, 3, 2, 1, 0 гэсэн тоон дүн болон процентон дүн хэрэглэнэ.
- 2.2. Үсгэн дүн тавихдаа доорх шалгуурыг үндэслэнэ.
  - А**-Сурлагын дээд амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг дээд зэрэг бүрэн гүйцэд, бүтээлчээр ойлгосон, ухагдахуун, ойлголтуудыг чадварлаг ашигладаг,
  - В**- Дундаж төвшнөөс дээгүүр амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг сайн ойлгосон, тухайн хичээлтэй холбоотой бодлого бодох, ухагдахууныг ашиглах чадвартай,
  - С** -Тухайн хичээлийн агуулгыг дундаж төвшинд эзэмшсэнийг илтгэх дүн. Тухайн хичээлийн ухагдхууны ихэнхи хэсгийг хангалттай ойлгосон, дундаж төвшний бодлогуудыг бодох чадвартай, цаашид энэ чиглэлээр хичээл судлах хангалттай бэлтгэлтэй,
  - Д**-Дундаж төвшинд дөхсөн амжилтыг илтгэх дүн.Тухайн хичээлийн ухагдхууныг жигд ойлгоогүй, харьцангуй хялбар бодлого бодох чадвартай, ерөнхийдөө мэдлэг, чадвар, дадал дутмаг,
  - F**- Мэдлэг, чадвар, хангалтгүйг илтгэх дүн.
  - E**- Оюутан сургалтанд бүрэн хамрагдсан боловч улирлын нэгдсэн шалгалтыг ямар нэгэн шалтгаанаар өгч чадаагүй тохиолдолд тухайн оюутны явцын оноо хүчинтэй байх ба шалгалтыг дахин авч явцын оноон дээр нэмж оюутныг үнэлэх үнэлгээ
  - R**- Оюутны ирц хангалтгүй, тухайн хичээлийн агуулгыг бүрэн эзэмшээгүй дахин судлах оюутныг үнэлэх үнэлгээ
  - U**- Оюутан дахин сургалтанд хамрагдахгүйгээр тухайн хичээлийн агуулгыг бие даан судалж мэдлэгээ дүгнүүлэх тохиолдолд ашиглана. Багш кредит шууд тооцох шалгалтыг оюутнаас авах тохиолдолд тухайн шалгалтын оноог 3.33-р үржүүлж оюутны мэдлэгийг дүгнэнэ.
- 2.3. Оюутан улирал тутамд сургалтын төлөвлөгөөний дагуу судалсан хичээлүүдийнхээ хөтөлбөрийн биелэлт болон сурах хөдөлмөр, мэдлэгийн төвшингөө 100 онооны процентон дүнгүүдээр дараах жишгээр харгалзуулан үнэлүүлнэ.

<sup>1</sup>	Процентон дун	Үсгэн дун	Тоон дун
1	97-100	A +	4
2	94-96	A	3.8
3	90-93	A -	3.6
4	87-89	B+	3.4
5	84-86	B	3.0
6	80-83	B -	2.7
7	77-79	C+	2.4
8	74-76	C	2.0
9	70-73	C -	1.7
10	67-69	D+	1.3
11	64-66	D	1.0
12	60-63	D -	0.7
13	00-59	F	0.0

2.4. Сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийн хөтөлбөрийн дагуу оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, түүний чанарын түвшинг шалгаж дүгнэх гол хэлбэр нь шалгалт байна. Шалгалт процессын хяналтын шалгалт болон улирлын нэгдсэн шалгалт гэсэн 2 хэлбэрээр явагдах ба тухайн хичээлээр эзэмшсэн онолын мэдлэгийн түвшин, мэдлэгээ практик үйл ажиллагаанд хэрэглэх, чадварыг дүгнэхэд чиглэгдэнэ.

2.5. Суралцсан хугацааны агуулга эзэмшилтийн чанарын төвшинг тогтооход голч дүн / ГД /-г ашиглана. Голч дүнг гаргахдаа оюутны тухайн хугацаанд судалсан хичээл бүрийн багц цагийг уг хичээлд авсан тоон дүнгээр харгалзуулан тус тусад нь үржүүлэн хооронд нь нэмээд гарсан нийлбэрийг тухайн хугацаанд судалсан хичээлүүдийн багц цагийн нийлбэрт хуваана. Голч дүнг тухайн улирлын голч дүн, хуримтлуулсан голч дүн гэж ангилна. Улирлын голч дүн нь тухайн нэг улиралд судалсан хичээлүүд, хуримтлуулсан голч дүн нь сургалтын эхний хичээлийн жилээс эхлэн тодорхой улирлыг дуусталх хугацаанд үзсэн бүх хичээлүүдийг оруулан голч дүнгээ дараах аргачлалаар тооцно.

**Өөрийн үнэлгээний голч дүнг олохдоо: Жишээ нь:**

№	Хичээлийн нэр	Багц цаг	Процентон дун	Тоон дүн	Багц цаг, тоон дүнгийн үржвэр	Голч дүн
1	Мат-1	3	90	A-(3.6)	$3 \text{ б/ц} * 3,6 \text{ т/д} = 10,8$	<b>18,25 н / 6,5 бцн = 2,8 голч</b>
2	Үйлдлийн системийн онол	1,5	80	B-(2,7)	$1,5 \text{ б/ц} * 2,7 \text{ т/д} = 4,05$	
3	Англ хэл	2	70	C-(1.7)	$2 \text{ б/ц} * 1,7 \text{ т/д} = 3,4$	
ᠶᠡᠭᠡᠳᠡ	Багц цагийн нийлбэр	6,5	Багц цаг, тоон дүнгийн үржвэрийн нийлбэр		18,25	

2.6. Сургалтын алба суралцагчдын мэдээллийн баазад оруулсан үнэлгээг тулган шалгаж, улирлын эцэст оюутны сурлагын чанарыг голч дүнгээр тодорхойлж дүгнэлт хийж хөтөлбөрийн чанарыг сайжруулах санал боловсруулж шийдвэрлүүлнэ.

2.7. Оюутан хичээлийн явцад бүрэн хамрагдаж, ирцээ бүртгүүлэх ёстой. Түр чөлөөг нэг хичээлд 8 цагаас илүүгүй олгож болно.

- Оюутан нэг цагийн чөлөө авах тохиолдолд тухайн хичээл заагч багшаас авна.

- Нэг өдрийн чөлөө авах тохиолдолд анги удирдсан багшаас авна.

- 2 түүнээс дээш хоногийн чөлөө авах тохиолдолд сургалтын албанд хандана.

2.8 Оюутан нэг хичээлийн нийт орох цагийн 70 хувьд суугаагүй тохиолдолд улирлын нэгдсэн шалгалтанд оруулахгүй ба тухайн хичээлийн агуулгыг дахин судлана.

2.9 Оюутан экстернат болон бусад хэлбэрээр суралцаж болно. Зохих шаардлагыг хангасан суралцагч хүсэлтээ тухайн улирал эхэлснээс хойш 2 долоо хоногийн дотор Захиргааны зөвлөлд хүсэлтээ илэрхийлнэ.

2.10. Сургалтын алба хичээл заагч багш нарын хамт хичээлийн жилийн эхэнд суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх журмыг бүх суралцагчдад бүрэн танилцуулсан байна.

2.11. Процентон үнэлгээ нь 3 хэсгээс бүрдэнэ. /100 онооны бүтэц, хуваарилалт/

А. 50 оноо – Сургалтын процессын үнэлгээ

Оюутны улирлын туршид сурах үйл ажиллагааны явцыг ирц, ирц, сэдвийн шалгалт, идэвхи орлцоо, бие даалтын ажил зэрэг төрлүүдийг ашиглан ам хэлбэрийг голчлон тухайн хичээл заагч багш 50 хүртэл оноогоор үнэлнэ. Уг үнэлгээг багш улирлын нэгдсэн шалгалт эхлэхээс өмнө оюутанд урьдчилан танилцуулж, оюутны мэдээллийн баазад тухайн оюутны явцын дүн үнэлгээг оруулсан байна.

Оюутны сургалтын процессыг үнэлэхдээ оюутнуудын мэдлэг, чадварыг үнэлэхээс гадна оюутны суралцах идэвхи, чармайлтыг дэмжих, хөдөлмөрийг үнэлэх, тэдэнд өөртөө дүгнэлт хийх боломжийг олгох, сануулга дохио өгөх, урамшуулж дэмжих, суралцах үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэрэгсэл талаас нь хандаж ажиллана.

**Б. 20 оноо–** Процессын хяналтын шалгалтыг тестийн хэлбэрээр авах бөгөөд уг үнэлгээ нь процессын үнэлгээнд тооцогдоно.

Сургалтын процессын үнэлгээ, процессийн хяналтын шалгалтын үнэлгээний нийлбэр 30 онооноос бага бол тухайн оюутныг улирлын нэгдсэн шалгалтанд оруулахгүй.

**В. 30 оноо –** Улирлын нэгдсэн шалгалт

2.12. Улирал бүрийн сургалт дуусмагц сургалтын албанаас баталгаажуулсан хуваарийн дагуу хичээл бүрээр улирлын нэгдсэн шалгалт авна. Тухайн шалгалтыг багш шалгалтын ложистикнийг баримтлан зохион байгуулна.

2.13. Улирлын нэгдсэн шалгалтын дүнг 24 цагт багтаан оюутны мэдээллийн баазад оруулан дүнгийн хуудсыг сургалтын албанд хүлээлгэн өгнө.

2.14. Сургуулийн оюутны мэдлэгийн үнэлгээг баримтжуулах үндсэн баримт бичиг бол шалгалтын дүнгийн хуудас байна.

2.15. Оюутнуудын үнэлгээнд улирал тутамд хяналт, үнэлгээ хийж, чөлөө олгох, улираах, хасах, шилжилт хөдөлгөөн хийх асуудлыг Сургалтын алба, мэргэжлийн тэнхимийн саналыг үндэслэн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

2.16. Суралцсан хугацааны хуримтлуулсан голч дүн 2.0-д хүрээгүй тохиолдолд бакалаврын зэрэг олгохгүй ба зөвхөн мэргэжлийн дипломтой төгсөнө.

2.17. Оюутан явцын үнэлгээ, процессын хяналтын шалгалтын үнэлгээ, улирлын нэгдсэн шалгалтын дүн үнэлгээгээ цаг тухайд нь онлайнгаар шалгана.

2.18 Улирлын нэгдсэн шалгалтыг тухайн улиралд зөвхөн нэг удаа авах ба сургалтын албанаас гаргасан хуваарийг шалгагч багш өөрчлөх эрхгүй.

2.19 Олон улсын түвшин тогтоох шалгалт болон мэргэжлийн байгууллагаар оюутны мэдлэгийн түвшинг шалгуулсан тохиолдолд тухайн үнэлгээг хичээлийн улирлын нэгдсэн шалгалт болон төгсөлтийн шалгалтын оноонд оруулан дүгнэж болно.

2.20. Улирлын туршид заасан хичээлийн агуулгыг оюутан өөрийн буруугаас эзэмшээгүй, шалгалтаа хугацаандаа өгч чадаагүйгээс хичээлийн нэгдсэн үнэлгээгээр F үнэлгээтэй дүгнэгдсэн оюутан багц цаг нөхөх сургалтын журмын дагуу дахин сургалтанд хамрагдаж мэдлэгээ дүгнүүлнэ. Багц цаг нөхөх шалгалт өгсөн, дахин хамгаалалтаар курсын ажил, дадлагын хамгаалалтанд орж мэдлэгээ дүгнүүлсэн оюутны авах дээд үнэлгээ 85/B/ үнэлгээнээс хэтрэхгүй байна.

1	Агуулга, нөхцөл	Багц цагийн төлбөр тооцоо	Шалгалтын хэлбэр
1.	Оюутан хичээлийн агуулгыг бүрэн судалж, шалгалтанд сургалтын төлбөрийн асуудлаас шалтгаалан ороогүй нөхцөлд	Тухайн хичээлийн багц цагийн төлбөрийн 50 хувийг төлөх	Шууд шалгалт өгнө.
2.	Шалгалтын үед оюутан хүндэтгэх шалтгааны улмаас албан ёсны чөлөө авсан нөхцөлд	Багц цагийн төлбөр төлөхгүй.	Шалгалтыг нөхөн өгөх эрх олгож үнэлгээг тооцно.
3.	Бусад бүх нөхцөлд	Тухайн хичээлийн багц цагийн төлбөрийг 100 хувь төлөх	Хичээлийн агуулгыг дахин судалж, сургалтанд хамрагдсаны үндсэн дээр шалгалт өгч мэдлэгээ дүгнүүлнэ.

2.21. Оюутанд харгалзан үзэх шалтгааныг үндэслэн улирлын нэгдсэн шалгалтыг урьдчилан буюу хойшлуулж өгөх эрхийг захиргааны зөвлөлийн шийдвэрээр олгож болно. Хойшлуулсан тохиолдолд тухайн оюутны улирлын шалгалтын үнэлгээнд харгалзах оноог нээлттэй тавьж үлдээнэ.

2.22. Хичээлийн жил бүрийн эцэст шалгагдсан нийт хичээлүүдээс 3, түүнээс дээш хичээлд F үнэлгээ авсан тохиолдолд улираан суралцуулна.

2.23. Төгсөлтийн ажлын сэдэв сонгох хүртэлх хугацаанд оюутны хуримтлуулсан сурлагын голч дүнгийн дундаж 3.0, түүнээс дээш үнэлгээтэй тохиолдолд дипломын ажил бичих эрх олгоно. Дээрх оноонд хүрээгүй боловч эрдэм шинжилгээний ажил бичих чадвартай оюутнуудыг холбогдох тэнхимийн саналыг үндэслэн Эрдмийн зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

2.24. Төгсөх ангийн оюутан дипломын ажлаа жинхэнэ хамгаалалтаар амжилтгүй хамгаалбал 5 багц цагийн төлбөр төлсний үндсэн дээр дахин хамгаалалтанд нэг удаа орж болно.

2.25.8 улирал суралцсаны эцэст оюутан төслийн ажлын хамгаалалт хийж, төгсөлтийн шалгалт өгнө. Төгсөлтийн шалгалтанд орж чадаагүй болон амжилтгүй шалгагдсан бол төгсөлтийн шалгалтын комиссийн гишүүдийн цагийн хөлсийг төлсний үндсэн дээр дахин орж болно.

2.26. Суралцах хугацаандаа 90 багц цаг цуглуулж ҮГД нь 3.0-аас дээш, В-ээс дээш дүнтэй суралцвал 3-р курсийг төгссөн оюутанд мэргэжлийн диплом олгож болно.

2.27. Сургалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, минимум 120 кредит цаг хуримтлуулж, төгсөлтийн шалгалтыг амжилттай өгсөн төгсөгчид бакалаврын зэрэг, мэргэжлийн диплом, энгэрийн тэмдэг олгоно.

2.28. Төгсөгч оюутан дипломоо хаяж үрэгдүүлбэл БСШУ-ны Сайдын 2006 оны 480-р тушаалаар батлагдсан “Дээд боловсролын диплом олгох журам” –ын 4.8-р зүйлийг баримтлан нөхөн авч болно.

2.29. Суралцагч оюутан суралцсан хугацааны дүнгийн баталгаажуулалтыг сургалтын сүлжээт төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанд Сургалтын албатай хийнэ.

2.30. Сургалтын төлбөр төлөөгүй, шалгалтын F үнэлгээтэй оюутнуудыг мэргэжлийн дадлагад гаргахгүй бөгөөд тайлан хамгаалалтанд оруулахгүй.

2.31. Сургалтын сүлжээт төлөвлөгөөнд заагдсан хугацаанд мэргэжлийн дадлагын тайлан, курсын ажлын хамгаалалтанд ороогүй болон хангалтгүй дүгнэгдсэн оюутан тухайн дадлагын багц цагийн тооцоог хийсний үндсэн дээр тайлан хамгаалалтанд дахин орох боломжтой.

2.32. Гадаадын болон бусад их, дээд сургуулиудаас шилжиж ирсэн оюутны сургалтын төлөвлөгөөний зөрүүг багц цагийн төлбөрийг төлүүлсний үндсэн дээр нөхүүлэх эрх олгоно.

2.33. Хичээл бүрийн үнэлгээний зэрэгцээ хөтөлбөрийн үндсэн үе шат бүрийн үр дүнг Хөтөлбөрийн хороо, тэнхимийн үнэлгээний баг дараах хэлбэрээр үнэлнэ.

- I. Түвшин тогтоох сорил
- II. Сэдвийн шалгалт
- III. Явцын үнэлгээ
- IV. Улирлын үнэлгээ

V. Ур чадварын үнэлгээ

**Гурав. Оюутны мэдлэгийг дүгнэх ажлын зохион байгуулалт**

**Бизнесийн ухааны тэнхимийн мэргэжлийн төгсөлтийн шалгалтын бүтэц, үнэлгээ:**

- Төслийн ажил- 100 оноо

Төслийн тэнхимийн хамгаалалтууд-60 оноо

Төслийн ажлын жинхэнэ хамгаалалт-40 оноо

- Мэргэжлийн төгсөлтийн шалгалт-100 оноо

- Peregrine шалгалт-50 оноо

- Төгсөлтийн шалгалт-50 оноо

**Инженер технологийн тэнхимийн мэргэжлийн төгсөлтийн шалгалтын бүтэц, үнэлгээ:**

**Мэргэжлийн төгсөлтийн шалгалт -100 оноо**

- Төслийн ажил-50 оноо

- Мэргэжлийн төгсөлтийн шалгалт-50 оноо

**Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн мэргэжлийн төгсөлтийн шалгалтын бүтэц, үнэлгээ:**

-Боловсрол судлалын төгсөлтийн шалгалт-100 оноо

-Мэргэжлийн төгсөлтийн шалгалт /ам/-100 оноо

-Мэргэжлийн төгсөлтийн шалгалт /бичиг/-100 оноо

**Магистрын төгсөлтийн нэгдсэн шалгалтын бүтэц, үнэлгээ**

-Төгсөлтийн нэгдсэн шалгалт-100 оноо

-Судалгааны ажил-50 оноо

-Төгсөлтийн нэгдсэн шалгалт-50 оноо

- Дадлагын үнэлгээ:

- Дадлагын удирдагч 10 оноо

- Хамгаалалтын комисс 90 оноо

- Курсын ажлын үнэлгээ, шалгуур:

А. Удирдагч багш -30 оноо

а. сэдвийн агуулга

б. цаг хугацааны баримтлал

в. төлөвлөгөөний хэрэгжилт

Б. Комиссын хамгаалалт

Бичилт - 50 оноо

- Онолын үндэслэл - 10 оноо

- Судалгаа, мэдээлэл боловсруулалт - 10 оноо

- Цаашдын чиг хандлага - 10 оноо

- Стандарт хангасан байдал – 10 оноо

- Үг үсгийн алдаа, найруулга зүй – 10 оноо Хамгаалалт - 20 оноо

- Ярих илтгэх чадвар - 10 оноо

- Сэдвийн хүрээнд олж авсан мэдлэг, чадварын цар хүрээ -10

- Дипломын ажил: Дипломын ажлын жинхэнэ хамгаалалтын үнэлгээ, шалгуур

Онолын хэсэг 20 оноо

Судалгааны хэсэг 20 оноо

Шинэ санаа 20 оноо

Ажилбар 10 оноо

Судалгааны арга барил 10 оноо

Дүгнэлт 20 оноо

## **СЭРҮҮЛЭГ ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ**

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 45,1, 45,2 Сэрүүлэг дээд сургуулийн дүрэм, Дотоод журмыг хэрэгжүүлэх үндсэн дээр өдөр тутмын сургалт, үйл ажиллагааг хэвийн явуулах, таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, суралцах үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүйн зарчим, хэм хэмжээг тогтоож, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд журмын зорилго оршино.

Сэрүүлэг дээд сургуулийн оюутны тангараг, оюутны эрхэмлэх есөн зүйлийг эрхэм болгож, хариуцлагатай ёс зүйн төлөвшилтэй суралцах нь оюутан хүний амжилтын үндэс болно.

#### **Нэг. Нийтлэг үндэслэл**

Энэхүү ёс зүйн дүрэм нь сургуулийн хичээлийн байр, оюутны дотуур байр, сургуулийн зүгээс гадуур зохион байгуулж байгаа олон нийтийн ажлын үед оюутны харилцааны соёл, олон нийтийн дунд биеэ авч явах байдал, ёс зүйн хэм хэмжээг зохицуулахад оршино.

#### **Хоёр. Оюутны ёс зүйн зөвлөлийн чиг үүрэг**

**2.1 Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа нь ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, оюутны ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол мэдээллийг холбогдох дүрэм журмын хүрээнд хянан шийдвэрлэнэ.**

**2.2 Ёс зүйн зөвлөл нь багш, ажилчид, оюутны төлөөллөөс бүрдсэн нийт 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг ерөнхий захирлын тушаалаар баталгаажуулна.**

**2.3 Ёс зүйн зөвлөл нь оюутны ёс зүйн дүрмийг сургуулийн хэмжээнд мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавина.**

#### **Гурав. Оюутны ёс зүйн журмаар хориглосон хэм хэмжээ**

3.1 Сургалтын орчны нийтийн үйлчилгээний зориулалтын эд хөрөнгө, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үзүүлэн самбар, ном сурах бичгийг урах, зориулалтын бусаар ашиглах, шилжүүлэн зөөх, авч явахыг;

3.2 Хичээлийн байранд сэлгүүцэх, хана налж зогсох, шатан дээр бөөгнөрч зогсох, шатны хөндлөвч болон цонхны тавцан, сургуулийн довжоон дээр гарч суухыг;

3.3 Сургуулийн хана, ширээ, сандал зэрэг орчны зүйлс дээр элдэв зүйл бичих, сийлэх, зурахыг ;

3.4 Хууль ёс, нийгмийн хэм хэмжээ, сургалт, шинжлэх ухааны үзэл баримтлалын эсрэг чиглэсэн сөрөг сурталчилгаа явуулахыг ;

3.5 Сургуулийн орчинд тамхи татах, согтууруулах ундааны зүйл хэрэглэх, согтуугаар хичээлд ирэхийг ;

3.6 Сургалтын орчин, хичээлийн анги, танхимд гадуур хувцас, малгай, биеийн тамирын хувцастай байх, ил задгай зохисгүй хувцаслахыг ;

3.7 Өөртөө болон бусдын аюулгүй байдал, эрүүл мэндэд нөлөөлөх элдэв зүйл, тэсэрч дэлбэрэх, шатамхай бодис зэрэг аюултай зэвсэг хэрэгсэл авч явахыг хориглоно.

3.8 Сургалтын үйл ажиллагаанд саад болох дараах үйлдлүүдийг хориглоно. Үүнд:

- Хичээл, сургалтын үед идэвхгүй суух, унтах, ярих
- Үймж шуугих, ноцолдох, гүйх, сэлгүүцэх
- Чанга дуу чимээ гаргах, чанга хөгжим сонсох
- Хаалгаар шагайх
- Утсаар ярих, мессеж бичих, тоглох, интернэтийн зохисгүй орчинд ажиллах, дуу хөгжим сонсох үйлдэл хийхийг
- Хичээлийн зохион байгуулалтыг эвдэх
- Бусдыг доромжлох, заналхийлэх, хуурч мэхлэх

3.11 Зориулалтын бус газар хог, цаас хаях, цонх, усны цоргыг нээлттэй орхихыг ;

- 3.12 Сургуулиас санаачилсан болон зохион байгуулсан үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулахыг ;
- 3.13 Хичээл сургалт явагдаж байхад чухал шаардлагагүй бол багш, оюутныг дуудах, тэднээр өөр ажил хийлгэх зэргээр сургалтаас хөндийрүүлэхийг ;
- 3.8 Суралцагч нь багшийн тавьсан дүн үнэлгээг засах, өөрчлөхийг ;
- 3.9 Шалгалтын өгөх явцад бусдад мэдээлэл өгөх, мэдээлэл авах, шалгалтанд зөвшөөрөгдөөгүй материал авч орох, ашиглах зэргийг ;
- 3.10 Суралцагч нь дүнгийн хуудас, сурлагын дэвтэр, оюутны үнэмлэх, тодорхойлолт диплом зэрэг албан бичиг баримтыг хуурамчаар үйлдэх, буруугаар ашиглах, бусдад шилжүүлэхийг ;
- 3.11 Сургалтын орчны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад сургалт, үйл ажиллагаанд оролцогч талууд хамтарч ажиллана.
- 3.12 Багшийн өгсөн даалгаварыг гүйцэтгэх, курс, диплом, төслийн болон бусад судалгааны ажилд суралцахдаа бусдын оюуны өмчийг хулгайлахыг ;
- 3.13 Интернет, цахим сүлжээ ашиглан бусдын оюуны өмчид халдах, эвдэх, садар самууныг сурталчлах, бусдыг гутаан доромжлох, нэр хүндэд халдахыг ;

#### **Дөрөв. Ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлага**

4.1. Сэрүүлэг дээд сургуулийн Оюутны ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд шат дараалсан арга хэмжээ авч хариуцлага тооцно.

Хүлээлгэх хариуцлага:

1. Ёс зүйн зөрчил гаргасан оюутны асуудлыг анги хамт олны хурлаар хэлэлцэнэ. /эхний удаа зөрчил гаргасан тохиодолд/
2. Мэргэжлийн тэнхим, ёс зүйн зөвлөлийн хамтарсан хурлаар оруулж торгох арга хэмжээ авна. /2 дахь удаагаа зөрчил гаргасан тохиодолд/
3. Сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар оруулж сургалтын гэрээг цуцалж, сургуулиас хөөх арга хэмжээ авна. /сургуулиас тавьсан шаардлагыг удаа дараалан биелүүлээгүй, бусдын суралцах үйл ажиллагаанд саад учруулсан гэж үзнэ./

Торгуулийн хэмжээ:

1. Сургуулийн эд хөрөнгө, хогшил, ном сурах бичиг, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжинд хохирол учруулсан, орчны хэвийн байдлыг алдагдуулсан буруутай этгээдээр хохирлыг 3 дахин нөхөн төлүүлэхээс гадна мөнгөн хэлбэрийн торгууль оногдуулна.
2. Сэрүүлэг дээд сургуулийн орчинд Монгол Улсын “Тамхины хяналтын тухай” хуулийн 9.1 дэх заалтыг зөрчиж, зориулалтын бус газар тамхи татсан оюутныг 50000 төгрөгөөр торгоно.
3. Хичээлийн байр, сургалтын анги танхим болон сургуулийн орчинд архи ууж, эрүүл бус байдалтай байгаа нь тогтоогдсон тохиолдолд эхний удаа хатуу сануулж, 100000 төгрөгөөр торгох ба 2 дахь удаа архи ууж, танхайрсан оюутанд сургуулиас хөөх хүртэл шат дараалсан арга хэмжээнүүдийг авна.

**Тав. Оюутны ёс зүйтэй холбоотой санал гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх**

5.1 Сэрүүлэг дээд сургуулийн багш, ажилтан ажилчид, оюутан суралцагч бүр ёс зүйн зөрчлийг гарсан даруйд таслан зогсоож, шаардлага тавих, ёс зүйгүй үйлдлийн талаар ёс зүйн зөвлөлд мэдээлэл өгөх үүрэгтэй.

5.2 Хичээл сургалтын явцад зөрчил гаргасан тавьсан шаардлагыг биелүүлээгүй оюутны талаар

5.3 Оюутны ёс зүйн дүрмийг зөрчсөн талаар багш, ажилтан оюутнаас гаргасан санал гомдлыг бичгээр хүлээн авч журмын дагуу шийдвэрлэнэ.

5.4 Сургуулийн орчинд гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргасан нь тогтоогдсон тохиолдолд цагдаа, хуулийн байгууллагад мэдэгдэж хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

5.5 Оюутны ёс зүйн зөвлөл, Сургалтын алба тэнхим, багш нар, ажилтан, оюутны холбоо, оюутан бүр энэхүү журмын биелэлтэнд тогтмол хяналт тавьж ажиллана.

## СЭРҮҮЛЭГ ДЭЭД СУРГУУЛИЙН “ШИЛДЭГ ОЮУТАН” ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

*Нэг. Нийтлэг үндэслэл*

Сэрүүлэг дээд сургуульд амжилттай сайн сурахын зэрэгцээгээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд тодорхой амжилт гаргасан, төрөл бүрийн үралдаан тэмцээнд идэвхитэй оролцож зохих үр дүнд хүрсэн, нийгмийн идэвхи зүтгэлээр тэргүүлж буй “Шилдэг оюутан”-ыг шалгаруулахад энэхүү журмын зорилго оршино.

*Хоёр: “Шилдэг оюутан”-д тавигдах шаардлага*

*Сэрүүлэг дээд сургуульд суралцагч шилдэг оюутан нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:*

*2.1. Оюутан нь 2 дугаар ангид буюу түүнээс дээш ангид суралцдаг байх*

*2.2. Сурлагын үнэлгээний голч дүн 2,8 ба түүнээс дээш байх*

*2.3. Оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажилд идэвхи санаачлагатай оролцож, тодорхой амжилт гаргасан байх*

*2.4. Судалгаа хийх чин хүсэл эрмэлзэлтэй, оролдлогтой, судалгааны ажлын чиглэлээ тогтоосон байх*

*2.5. Оюутны хөгжлийн хөтөлбөр, бусад их, дээд сургуулиудын хүрээнд зохион байгуулагддаг олон нийтийн ажил, урлаг, спортын аль нэг төрлөөр тодорхой амжилт гаргасан байх*

*2.6. Сургууль, алба, тэнхим, оюутны холбоо, анги хамт олон, олон нийт болон клубуудын зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд идэвхитэй оролцогч, санаачлагч, зохион байгуулагч байх*

*2.7. Мэргэжлийн ур чадвараараа сургуульдаа манлайлагч байх, хичээл бүр дээр манлайлагч байх*

*2.8 Нийгмийн ажилд идэвхитэй, зохион байгуулах ур чадвартай байх*

*2.9 Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх*

*2.10 Бусдаас суралцаж, мэдлэгээ хуваалцдаг, шинэ санаа дэвшүүлдэг байх*

*2.11 Цаг үеийн мэдээ мэдээллийг сургуулийн web site, facebook, twitter-ээс авч хариу өгч хамтран ажилладаг байх*

*2.12 Сургуулийн дотоод дүрэм журмын заалтуудыг зөрчөөгүй байх шаардлагатай.*



**2.13 Мэргэжлийн тэнхимээс нэр дэвшиж гарсан шилдэг оюутан, шилдэг анги хамт олны шалгаруулалтын мэдээллийг Сэрүүлэг дээд сургуулийн [www.seruuleg.edu.mn](http://www.seruuleg.edu.mn) веб сайтаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.**

Гурав: Шалгаруулалт

3.1. Мэргэжил тус бүрээс энэхүү шаардлагыг хангасан нэг оюутныг шалгаруулна.

3.2 Шилдэг оюутан шалгаруулах шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулна.

- Нэгдүгээр үе шат Шилдэг оюутны тодорхойлолтыг мэргэжлийн тэнхим хэлэлцэх /Анги удирдсан багш хариуцсан ангиасаа нэр дэвшиж байгаа оюутнуудын материалыг хүлээн авч тэнхимийн хурлаар хэлэлцүүлнэ./

/2015 оны 11 сарын 11-ний өдрөөс 27-ны өдөр хүртэл

- Хоёрдугаар үе шат мэргэжлийн тэнхимээс нэр дэвшүүлэн гаргаж ирсэн шилдэг оюутны тодорхойлолтыг захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж шалгаруулна.

/2015 оны 12 сарын 10-ны өдөр/

## **СЭРҮҮЛЭГ ДЭЭД СУРГУУЛИЙН “ШИЛДЭГ АНГИ ХАМТ ОЛОН” ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

**Сэрүүлэг дээд сургуульд анги хамт олноороо амжилттай сайн суралцаж, “Оюутны хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулагдсан уралдаан тэмцээнд идэвхитэй оролцож зохих амжилт гаргасан, нийгэм, олон нийтийн үйл ажиллагаанд идэвхи, санаачлагатай оролцдог “Шилдэг анги хамт олон”-ыг шалгаруулахад энэхүү журмын зорилго оршино.**

### **Хоёр: “Шилдэг анги хамт олон”-д тавигдах шаардлага**

Сэрүүлэг дээд сургуулийн шилдэг анги хамт олон нь дараах шаардлага хангасан байна. Үүнд:

2.1. Анги хамт олноороо сурлагын 100 хувийн амжилттай суралцсан байх

Анги хамт олны сурлагын чанар 60-аас дээш хувьд хүрсэн байх

2.2. Мэргэжлийн болон бусад чиглэлээр уралдаан тэмцээнд амжилттай оролцож, сургуулийн нэрийг гаргасан байх

2.3. Тус сургуулийн “Оюутны хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулагдсан урлаг, спортын арга хэмжээнүүдэд тухайн хичээлийн жилийн турш анги хамт олноороо идэвхитэй оролцож, тодорхой амжилт гаргасан байх

2.4. Сургуулийн дотоод дүрэм, журмыг мөрдлөг болгон суралцаж ёс зүйтэй хамт олон болсон байх

2.5 Анги хамт олноороо нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг санаачилсан байх

2.6 Анги хамт олноос сургууль болон бусад байгууллагын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан оюутантай байх

2.7. Шинэ санаа дэвшүүлдэг, бүтээлч оюутны ангид эзлэх хувь өндөр байх

2.8 Сургуулийг хөгжүүлэх үйлсэд анги хамт олноороо санаачлага гарган бүтээн байгуулалтын ажил хийсэн байх

2.9 Сургалтын орчныг сайжруулахад идэвхи санаачлагатай оролцож эко орчныг бүрдүүлэх

2.10 Анги хамт олноороо мэргэжлийн имидж бүрдүүлж хичээл сургалтын үйл ажиллагаанд оролцож байх

2.11 Мэргэжлийн тэнхимээс нэр дэвшиж гарсан шилдэг оюутан, шилдэг анги хамт олны шалгаруулалтын мэдээллийг Сэрүүлэг дээд сургуулийн [www.seruuleg.edu.mn](http://www.seruuleg.edu.mn) веб сайтаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

**Гурав: Шалгаруулалт**

3.1. Шилдэг анги хамт олны шалгаруулалтыг 2 үе шаттай явуулах бөгөөд шалгаруулалтыг нээлттэй, ил тод, зохион байгуулна.

Мэргэжил тус бүрээс энэхүү шаардлагыг хангасан нэг анги хамт олныг шалгаруулна.

3.2 Шилдэг анги хамт олон шалгаруулах шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулна.

- Нэгдүгээр үе шат Шилдэг анги хамт олны тодорхойлолтыг мэргэжлийн тэнхим хэлэлцэх /Анги удирдсан багш хариуцсан ангиасаа нэр дэвшиж байгаа оюутнуудын материалыг хүлээн авч тэнхимийн хурлаар хэлэлцүүлнэ./

/2015 оны 11 сарын 11-ний өдрөөс 27-ны өдөр хүртэл

- Хоёрдугаар үе шат мэргэжлийн тэнхимээс нэр дэвшүүлэн гаргаж ирсэн шилдэг анги хамт олны тодорхойлолтыг захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж шалгаруулна.

/2015 оны 12 сарын 10-ны өдөр/

## **СЭРҮҮЛЭГ ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ШАГНАЛ УРАМШУУЛЛЫН ЖУРАЙ**

### **Нийтлэг үндэслэл:**

Сэрүүлэг дээд сургуульд 4 жил суралцах хугацаандаа сурлага хөдөлмөр, авьяас чадвар, урлаг спорт, эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр өндөр амжилт гаргасан шилдэг, манлайлагч оюутнуудыг шалгаруулж дэмжих, суралцагчдыг идэвхижүүлж урамшуулахад энэхүү журмын гол зорилго оршино.

Нэг: Оюутны сурлагын амжилт, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд гаргасан амжилтыг үнэлж, шагнаж урамшуулах

1.1 Суралцагч оюутан нь эхний 4 улирал дараалан А,В үнэлгээтэй суралцсан тохиолдолд сурлагын голч дүнг харгалзан Жаргал сангийн тэтгэлэгийн сургалтын төлбөрийн 50-100%-ийн хөнгөлөлт олгоно. Дараагийн хичээлийн жилд нь үнэлгээний голч дүнгээ хадгалан амжилттай суралцаж байгаа тохиолдолд тэтгэлэгийг үргэлжлүүлэн олгоно.

1.2 Жил бүр оны “Шилдэг анги хамт олон”, “Шилдэг оюутан” шалгаруулах журмын дагуу шилдэгүүдийг тодруулж мөнгөн шагнал олгоно.

1.3 Улсын хэмжээний олимпиад, уралдаан тэмцээнд эхний 3 байр эзэлсэн тохиолдолд тухайн оюутны сургалтын төлбөрийг 50% хөнгөлнө.

1.4 Тус сургуулиас зохион байгуулдаг “Боломж” эрдэм шинжилгээний бага хурал, эссэ бичлэг, илтгэлийн уралдаанд шагналт байр эзэлсэн оюутнуудыг мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

1.5 Оюутны холбоо, оюутны холбооны тэргүүлэгч гишүүдэд сонгогдон ажиллаж байгаа манлайлагч оюутнуудад тухайн хичээлийн жилд гадагшаа чиглэсэн болон олон нийтийн ажилд оюутнуудыг оролцуулсан байдал, зохион байгуулсан ажлын гүйцэтгэлийн үр дүнг харгалзан сургалтын төлбөрөөс тодорхой хувь хөнгөлнө.

### **Хоёр. Оюутны урлаг, спортын амжилтыг үнэлж, шагнаж урамшуулах**

2.1 Оюутны хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагддаг урлаг, спортын наадамд түрүүлсэн оюутан, анги хамт олныг мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

2.2 Улс, хот, бүсийн хэмжээний урлаг, спортын тэмцээнд амжилт гарган эхний 3 байрын шагнал хүртэж, сургуулийн нэр хүндийг гаргасан тохиолдолд сургалтын төлбөрийн 20%-ийн хөнгөлөлт олгоно.

Гурав: Оюутны сургалтын төлбөрийн хөнгөлөлтүүд

3.1 Тухайн мэргэжлийн ерөнхий шалгалтын оноо 600-с дээш тохиолдолд сургалтын төлбөрийн 10% хөнгөлөх

3.2 Сэрүүлэг дээд сургуулийн нэрэмжит олимпиадад 1-р байр эзэлсэн суралцагчийн 4 жилийн 2-р байр эзэлсэн суралцагчийн 2 жилийн, 3-р байр эзэлсэн суралцагчийн 1 жилийн сургалтын төлбөрөөс 100% хөнгөлнө.

3.3 Нэг гэр бүлээс 2 ба түүнээс дээш оюутан тус сургуульд суралцаж байгаа тохиолдолд нэг суралцагчийн сургалтын төлбөрийг эхний хичээлийн жилд 20% хөнгөлнө.

3.4 Сэрүүлэг дээд сургуулийн төгсөгчид боловсролын зэрэг ахиулахаар сургуулийнхаа магистрантурын хөтөлбөрт суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийн 20% хөнгөлнө.

3.5 Шагнал урамшуулал авсан шилдэг манлайлагч оюутан суралцагчдыг олон нийтэд сурталчилна.

**Монгол Улсын Засгийн газар, БШУЯ, Сургалтын төрийн сангийн  
хөнгөлөлт нөхцөлүүд**

Засгийн газрын 19 тогтоолын дагуу Сургалтын төрийн сангаас суралцагчдад үзүүлдэг хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн нөхцөлөөр суралцах боломжтой.

Оюутан бүр үндэсний тэтгэлэг болон урамшууллын тэтгэлэг авах боломжтой.

Магадлан итгэмжлэгдсэн сургуулиудын амжилттай сайн суралцаж байгаа оюутанд олгодог байгууллагуудын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжтой.

БШУЯ-наас жил бүр зарладаг гадаад улс орнуудад бакалавр, магистрын сургалтанд Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрөөр 5 оюутныг суралцуулах боломжтой.